



130

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Техникийн ажлын хэсэг  
байгуулах тухай

Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, техникийн ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)- д даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



00173?

Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**Техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

- Дарга ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Орлогч дарга ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга ЭМЯ-ны НЭМХ-ийн ХБӨ-ний хяналт, сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд ЭМЯ-ны НЭМХ-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал хариуцсан мэргэжилтэн;
- ЭМЯ-ны НЭМХ-ийн Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал хариуцсан мэргэжилтэн;
- ЭМЯ-ны ЭТХ-ийн Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тогтолцооны судалгааны албаны дарга;
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан захирал;
- ЭМЯ-ны хоол судлал, хүнсний аюулгүй байдлын ерөнхий мэргэжилтэн;
- Хавдар судлалын үндэсний төвийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал;
- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Яаралтай тусlamж эрхэлсэн дэд захирал;

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 60 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулах техникийн ажлын хэсгийн ажиллах журам**

**Нэг. Ерөнхий чиг үүрэг**

- 1.1 Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- 1.2 Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үйл ажиллагаанд тулгамдсан асуудлын талаар санал боловсруулан шийдвэрлүүлэх,
- 1.3 Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулах,
- 1.4 Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэгч үндэсний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх

**Хоёр. Ажиллах журам**

- 2.1 Ажлын хэсэг улиралд нэг удаа хуралдана.
- 2.2 Шаардлагатай үед ээлжит бус хурлыг тухай бүр хуралдуулна.
- 2.3 Гишүүдийн олонхийн ирц бурдсэнээр ажлын хэсгийн хурал хүчин төгөлдөр болно.
- 2.4 Асуудлыг хуралд оролцогчдын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.5 Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх асуудлыг 3-5 хоногийн өмнө гишүүдэд тараж зарлана.
- 2.6 Ажлын хэсгийн гишүүд холбогдох асуудлаараа хурлын нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

**Гурав. Эрх**

- 3.1 Хурлын шийдвэрийг шаардлагатай үед холбогдох байгууллага, хүмүүст мэдэгдэх
- 3.2 Хамтран ажиллагч байгууллага, хүмүүсийг хуралд урилгаар оролцуулан илтгэл, мэдээллийг гаргуулах
- 3.3 Харъяа байгууллагаас шаардлагатай мэдээллийг гаргуулах
- 3.4 ДЭМБ, бусад олон улсын, төрийн болон төрийн бус байгууллагаас мэдээлэл хүсэх
- 3.5 Хурлаас гарсан тэмдэглэл, зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах, биелэлтийн тайлан гаргуулах



3.6 Шаардлагатай асуудлыг зохих журмын дагуу удирдлага, дээд шатны байгууллагад тавих

**Дөрөв. Үүрэг**

- 4.1 Хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг үр дүнтэй уялдуулж мэдээлэл харилцан солилцож байх
- 4.2 Хөтөлбөр, төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлантай танилцаж дүгнэлт хийх, зөвлөмж гаргах
- 4.3 Хөтөлбөр, төслийн шугамаар гадад, дотоод томилолтоор ажилласан мэргэжилтний илтгэл, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд нь дэмлэг үзүүлэх
- 4.4 Хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанд гарсан шинэ санаа, арга барил, туршлагыг нэгтгэн нийтэд түгээхэд дэмжлэг үзүүлэх
- 4.5 Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах асуудлаар шийдвэрлэвэл зохих асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд зохих журмын дагуу тавьж шийдвэрлүүлэх